



“Бүх нийт боловсролын төлөө!”  
Иргэний нийгмийн үндэсний эвсэл

**ХУВИЙН СУРГУУЛИУДЫГ ТӨРӨӨС  
ЗОХИЦУУЛАХ ШААРДЛАГА**

**НӨЛӨӨЛЛИЙН БАРИМТ  
БИЧГИЙН ТОЙМ**

УИХ МН  
СУДАЛГААНЫ САН

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН



“Бүх нийт боловсролын төлөө!”  
Иргэний нийгмийн үндэсний эвсэл

*Хувийн сургуулиудыг төрөөс  
зохицуулах шаардлага*

**НӨЛӨӨЛЛИЙН БАРИМТ  
БИЧГИЙН ТОЙМ**

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

Улаанбаатар хот  
2018 он

Дэлхийн хүн бүр, эмэгтэй, эрэгтэй, хүүхэд, залуус, насанд хүрэгч ялгаагүй боловсрол эзэмших, насан туршдаа суралцах эрхтэй. Энэ бол 2015 онд дэлхийн улс орнуудын засгийн газруудын баталсан Тогтвортой хөгжлийн 4-р зорилго болох «Тэгш хамран сургалт, эрх тэгш байдлыг хангасан чанартай боловсролыг бүх нийтэд олгох, насан туршид суралцах боломжийг дэмжих» үзэл баримтлал юм. Хүн бүр боловсрол эзэмших эрхтэйн адилаар улс орон бүр олон улсын хууль, эрх зүйн дагуу энэ эрхийг хүндэтгэж, хамгаалах, хангах үүрэгтэй. Хүн бүрийн үнэ төлбөргүй, чанартай боловсрол эзэмших энэхүү эрхийг баталгаажуулах эцсийн хариуцлагыг төр хүлээдэг.

Сурч боловсрох эрхийг хэрэгжүүлэхээр боловсролын үйлчилгээг төрийн бус салбарын оролцогчид болох хувийн компаниуд, шашны байгууллагууд, ТББ-ууд, орон нутгийн бүлэг, хамт олон, сангууд болон хувь хүмүүс эрхлэн хүргэж байна.

### Боловсрол олгож буй нийтлэг хэлбэрүүд<sup>1</sup>

	Хувийн хэвшлээс боловсрол олгох	Төрөөс боловсрол олгох
Хувийн санхүүжилт	<ul style="list-style-type: none"> <li>Төлбөртэй хувийн сургуулиуд</li> <li>Гэрийн сургууль</li> <li>Төсвөөс татаас авдаггүй орон нутгийн, шашны, эсвэл төрийн бус байгууллагын сургууль/сургалтын төвүүд</li> <li>Төсвөөс татаас авдаггүй хичээлээс гадуурх сургалт /төлбөртэй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Төлбөр төлж сурдаг улсын сургуулиуд</li> <li>Хувь хүний болон байгууллагын хандив дэмжлэгтэй улсын сургуулиуд</li> <li>Хувийн хэвшлийн тэтгэлэгтэй улсын сургуулиуд</li> </ul>
Төсвийн санхүүжилт	<ul style="list-style-type: none"> <li>Засгийн газрын ваучер, татаас, тэтгэлгээр санхүүждэг хувийн сургуулиуд</li> <li>Боловсролын үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх</li> <li>Хувийн компаниудын ажиллуулдаг улсын сургуулиуд</li> <li>(заримдаа үнэгүй, тусгай эрхийн гэж нэрлэдэг)</li> <li>Татаас авдаг орон нутгийн, шашны, эсвэл төрийн бус байгууллагын сургууль/сургалтын төвүүд</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Үнэ төлбөргүй улсын сургуулиуд</li> </ul>

1 - хувийн сургуулиудын уламжлалт хэлбэрүүд

2 - улсын сургууль

3 - хувийн санхүүжилтээр бүхэлдээ эсвэл хэсэгчлэн санхүүждэг төрийн сургуулиуд (холимог загвар буюу ТХХТ)

4 - төрийн санхүүжилтээр бүрэн эсвэл хэсэгчлэн санхүүждэг хувийн сургуулиуд (холимог загвар буюу ТХХТ)

1 Боловсролын төлөөх Дэлхийн аян хөдөлгөөнөөс (GCE) гаргасан “Private profit, Public Loss” тайлан

Эдгээр төрийн бус оролцогч талууд үндэсний түвшинд үүрэг хариуцлага хүлээдэг байх нь чухал болохыг НҮБ-ын хүний эрхийн хороод болон хүний эрхийн тусгай илтгэгчид сануулах боллоо.

Төрийн бус, хувийн хэвшлийн этгээдүүдийн боловсролын үйл ажиллагааг хөтлөн явуулах үзэл баримтлал, сэдэл тэмүүлэл нь ялгаатай байж болох ч ямагт хүний эрхийн зарчмуудыг удирдлага болгох учиртай.

## БОЛОВСРОЛЫН ХУВЬЧЛАЛЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН (СҮҮЛИЙН ҮЕИЙН) ХАНДЛАГААС

Боловсролын салбар дахь хувьчлал нь цар хүрээ, хэлбэр, шинж чанараараа улс орон бүрт өвөрмөц байдаг ч дэлхийн хэмжээнд нийтлэг ажиглагдаж байгаа хэд хэдэн хандлага байна. Сүүлийн 10-15 жилийн хугацаанд дэлхий даяар боловсролын салбарын хувьчлал олон хэлбэрээр хийгдэж, тоо хэмжээ нь нэмэгдсэнийг нотолгоо харуулдаг<sup>2</sup>. Үүнд:

**Газар зүйн хувьд тархаж байна.** Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагын (OECD) орнуудаас илүүтэйгээр өмнөд бүс нутгийн орнуудад; мөн боловсролын салбарт нь хувийн хэвшил томоохон байр суурь эзэлдэг орнуудаас авахуулаад огт хувьчлал байхгүй улс орнуудад хүртэл хувийн сургуульд элсэлт нэмэгдэх зэргээр чиг хандлага өөр өөр байна. Түвшингийн хувьд сургуулийн өмнөх боловсрол болон дунд сургуулийн хамрагдалт илүү өсөлттэй гарч байна.

**Компанид тулгуурласан ашгийн төлөөх хэлбэр өсч байна.** Дэлхий даяар боловсролын салбарт ашгийн төлөөх оролцоо өргөжсөн байна. Бага, дунд орлоготой орнуудад боловсролын салбарыг дэлхийн хэмжээний бизнес, хөрөнгө оруулагчдад ихээхэн ашиг олох боломжтой, ашигтай зах зээл гэж ойлгох явдал улам бүр өсөн нэмэгдэж байна. Боловсролын хувьчлал нь дээр дурдсан аль нэг холимог хэлбэрийн хүрээнд өргөжиж, аажимдаа боловсрол бүхэлдээ төрийн/нийтийн байх зарчмыг түрэх хандлага нэмэгдэж байна.

**«Бага төлбөртэй» хувийн сургуулиуд, тусгай эрх олгосон сургуулиуд, ваучерийн болон "сүүдрийн" (shadow education system) боловсролын байгууллага, сургуулиуд өсч байна.** Бага төлбөртэй гэх хувийн сургуулиуд байгуулах, төр болон хувийн хэвшлийн түншлэл нэрийн дор "төрийн" сургуулиудыг хувийн хэвшил удирдаж ажиллуулах, заримдаа тусгай эрхтэй нэрийн дор ашгийн төлөө ажиллах, эсвэл тусад нь засгийн газрын буцалтгүй

2 *Public good over private profit, Иргэний нийгмийн байгууллагуудад зориулсан гарын авлага.* Боловсролын төлөөх Дэлхийн аян хөдөлгөөн (GCE)

тусламж үзүүлж, хувийн сургуулийн төлбөрийг төлөх буюу татаас олгох, мөн хичээлээс гадуурх төлбөртэй сургалт явуулдаг «сүүдрийн» хэлбэрээр ажиллаж байна. Боловсролын салбар дахь хувийн хэвшлийн эдгээр хэлбэрүүд өргөжсөнөөр тэдэнд нэлээд ашигтай байж болох ч, боловсрол эзэмших эрхийг зөрчихөд хүргэж, бүх нийтээр тэгш шударга, чанартай боловсрол эзэмшихэд илэрхий саад тотгор учруулж байгааг нотолгоо харуулж байна.

**Төрөөс олгох боловсролын үйлчилгээг ашгийн төлөө байгууллагад аутсорсинг хийх хандлага өсч байна.** Хэдийгээр дэлхийн нийтлэг чиг хандлага биш ч Либери зэрэг зарим улсад засгийн газар нь боловсролын тогтолцооны томоохон хэсгийг хувийн хэвшилд аутсорсинг хийх туршилтын загварыг санаачилсан байдаг. Үүнийг маш болгоомжтой ажиглах нь чухал болно.

**Хувьчлалыг эсэргүүцэх хандлага өсч байна.** Эцэг эх, олон нийт, хүний эрхийн байгууллагууд, иргэний нийгмийн зарим байгууллагуудын<sup>3</sup> үйл ажиллагаагаар дээрх чиг хандлагыг эсэргүүцэх явдал улам бүр нэмэгдсээр байна. Байршил, хөгжлийн бэрхшээл, эсвэл бусад шинж чанараас үл хамааран боловсролыг бүх нийтэд хүртээмжтэй, үнэ төлбөргүй, чанартай олгохын төлөө төрийн бодлого, үйл ажиллагаа, олон улсын хэм хэмжээ, санхүүжилт, гэрээ хэлэлцээрүүдэд нөлөө үзүүлэх бодлогын нөлөөллийн арга хэмжээнүүд явагдсаар байна.

**Нэгдсэн Үндэстний Байгууллага болон эрхийн байгууллагуудын зүгээс зэмлэн буруушааж байна.** Хүний эрхийн болон боловсролын чиглэлээр ажилладаг олон улсын байгууллагуудын мэдэгдэл, үйл ажиллагаа дээрх эсэргүүцлийг улам хүчтэй болгож байна. НҮБ-ын Сурч боловсрох эрхийн тусгай илтгэгчид хувьчлалын эсрэг санал дэвшүүлсээр байна. Жишээ нь 2015<sup>4</sup> онд “Боловсролыг нийтийн сайн сайхны төлөө үйлчлэхэд хувьчлал хор нөлөөтэй” гэж үзэж байсан бол 2016 онд НҮБ-ын тогтоолоор “Боловсрол ашгийн төлөө, арилжааны хэлбэрийн болсноос гарах аливаа сөрөг үр дагавар”-т анхаарч, боловсролын салбар дахь хувийн хэвшлийнхнийг төрөөс зохицуулахыг уриалсан байна<sup>5 6</sup>.

- 3 Олон Улсын Боловсрол (EI)-ын багш нарын олон улсын холбоо, Боловсролын төлөөх Дэлхийн аян хөдөлгөөн (GCE), Ази, Номхон Далайн Бүсийн Суурь болон насанд хүрэгчдийн боловсролын холбоо (ASPBAE), Бүх нийтийн Боловсролын төлөөх латин америкийн холбоо (ACEA), Африкийн Сүлжээ (ANCEFA), Боловсролын салбарын хувьчлал ба Хүний эрхийн консерциум (PEHRC) гэх мэт
- 4 Singh (2015) Report of the Special Rapporteur on the Right to Education [http://www.un.org/en/ga/search/view\\_doc.asp?symbol=A/70/342](http://www.un.org/en/ga/search/view_doc.asp?symbol=A/70/342)
- 5 Human Rights Council resolution A/HRC/32/L.33 (2016) - [www.right-to-education.org/sites/right-to-education.org/files/resource-attachments/HRC\\_Resolution\\_Right\\_to\\_Education\\_2016\\_En.pdf](http://www.right-to-education.org/sites/right-to-education.org/files/resource-attachments/HRC_Resolution_Right_to_Education_2016_En.pdf)
- 6 The Global Initiative for Economic, Social, and Cultural Rights has summarised all UNHR bodies' comments and observations adopted from September 2014 to June 2017: [http://globalinitiative-escr.org/wp-content/uploads/2016/10/GIE-SCR-CRC\\_CESCR\\_CEDAW-synthesis-statements-on-private-actors-in-education.pdf](http://globalinitiative-escr.org/wp-content/uploads/2016/10/GIE-SCR-CRC_CESCR_CEDAW-synthesis-statements-on-private-actors-in-education.pdf)

## ЯАГААД ИЙНХҮҮ ЭСЭРГҮҮЦЭЖ, ЗЭМЛЭН БУРУУШААХ БОЛОВ?

Боловсролын төлөөх Дэлхий Аяны (GCE) олон гишүүн байгууллагуудын хуримтлуулсан туршлага, эрдэмтэд, судлаачид, сэтгэгчдийн болон бусад олон хүмүүсийн цуглуулсан нотолгоонууд хувьчлалын өнөөгийн чиг хандлагын бодит үр нөлөө, болзошгүй хохирлыг тодорхойлж байна. Мөн Ази, Номхон далайн бүсийн түвшинд үүссэн нөхцөл байдлаас харахад боловсролын үйлчилгээг хувьчилж, боловсролд ТХХТ-ийг хүчтэй дэмжиж, ялангуяа боловсролын салбар нь санхүүжилтийн хомсдолд орсон, эсвэл боловсролын үйлчилгээг хүргэж чадахгүй төр бүхий улсуудад явагдаж байгаа хувьчлал, ТХХТ-ийн асуудал нь засгийн газрууд, хандивлагчид, НҮБ-ын агентлагууд, олон улсын банк санхүүгийн байгууллагын анхаарлыг татаж байна.<sup>7</sup>

Боловсрол дахь хувьчлал болон боловсролыг бизнес гэж үзэх хандлага өсөн нэмэгдэж буй нь олон улсын хэмжээнд сэтгэл зовоосон асуудал болж байна. Энэ нь дан ганц хувийн нэг (сайн, муу) сургуулийн асуудал биш харин хүүхэд бүрт үнэ төлбөргүй, *чанартай* боловсрол олгох төрийн үйл хэрэгт түүний үзүүлэх нөлөө, хувь нэмрийн тухай асуудал юм. Ялангуяа ашгийн төлөө болон төлбөр төлдөг боловсролыг өргөжүүлэх нь улс орон хүлээсэн үүргийнхээ дагуу нийтлэг чанар, тэгш байдал, чанартай боловсрол олгоход зориулах нэн хэрэгцээтэй санхүүжилт өөр тийш чиглэхийн зэрэгцээгээр боловсролын тогтолцоонд гадуурхал, тэгш бус байдал улам нэмэгдэх асуудлыг үүсгэж байна.

1970-аад онд улс орнууд боловсролын үйлчилгээг хүргэхдээ өөр өөр арга замуудыг судлан сонгож, хэрэгжүүлж эхэлсэн байдаг. Жишээ нь, Чили улсад боловсролын хувьчлалын неолиберал туршилтыг батлан хэрэгжүүлж эхэлсэн бол Финланд улс боловсрол дахь тэгш байдалд гол анхаарлаа төвлөрүүлж эхэлжээ. Ингээд 2000 он гарснаас хойших байдлаар хүрсэн ялгаатай үр дүнгүүдийг Олон улсын сурагчийн үнэлгээний хөтөлбөрт (PISA) оролцдог улс орнуудын жагсаалтаас харж болно. 2011 он гэхэд Чили улсад олон зуун мянган хүн боловсролын тогтолцоогоо эсэргүүцэж, тэмцэл өрнүүлж байсан бол 2000-аад онуудад Финланд улс PISA-д тогтмол дээгүүр байранд жагссаар байна. Хувьчлал бүхий боловсролын тогтолцооны үр дүнд боловсролын хүртээмжтэй байдал сургуулийн төрлөөр хязгаарлагдсан (Чили); бүх нийтийн боловсролын тогтолцоонд хариуцлага, ил тод байдлаас гадуур оршдог сургуулиуд түрэн орж ирсэн (Швед); сурлагын амжилт, гүйцэтгэл арьс өнгө, үндэс угсаа болон анги давхаргаар ялгаатай гардаг (АНУ) байдал үүссэн бол боловсрол бүхэлдээ төрийн ивээлд байснаар багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх зэргээр багшийн чанарыг

7 ASPBAE, Gain or drain? Understanding Public - Private Partnerships in Education, 2013 оны 7 дугаар сар. 74 дүгээр тал. Дэлгэрэнгүйг: <http://www.periglobal.org/sites/periglobal.org/files/Gain%20or%20Drain%20Understanding%20Public%20Private%20Partnerships%20in%20Education.pdf>

сайжруулахад дорвитой хөрөнгө оруулж чаддаг (Куба); тэгш байдалд анхаарал хандуулах нь чанаржих илүү сайн үр дүнд хүргэдэг (Финлянд); захиргаа, багш нар, эцэг эхчүүд зэргээр системийг бүхэлд нь хамарсан шинэчлэл хийгдэж чаддаг (Онтарио, Канад) гэсэн гол үр дүнг<sup>8</sup> дурджээ.

Олон улсын түвшинд<sup>9</sup> ТХХТ-ийн талаар 2008-2013 онд хийсэн 59 судалгааны тайланг харьцуулсан эмхэтгэлд Хөгжиж буй улсуудын хүүхдүүдийн боловсролыг хувийн хэвшлийн ЕБС сайжруулж чадах уу? гэсэн судалгааны асуултад хариулахаар зорьсон ба сургалтын үр дүн, үр ашиг, тэгш болон хүртээмжтэй байдал, чанарын талаарх нотлох баримт нь дэмжсэн, үгүйсгэсэн, тодорхой бус эсэхээр дүгнэлт хийжээ. Хөгжиж байгаа улсуудын хувийн хэвшлийн ЕБС-иудын хамрах хүрээ, олон янзат байдлын тухай мэдээлэл дутмаг учир тодорхойлох боломжгүй, хувийн сургуулийн талаарх мэдээллийн дийлэнх нь албан ёсны бүртгэлтэй хувийн сургуулийн хүрээг хамарсан хязгаарлагдмал байдалтай байсан байна. Хувийн хэвшлийн ЕБС-д хичээл зааж байгаа байдал, багшийн ирц, идэвх, хандлага, аргагүй төрийн өмчийн ЕБС-иас илүү байгаа нь сургалтын үр дүнд эерэгээр нөлөөлдөг. Хувийн хэвшлийн ЕБС ажил олгогчдынхоо өмнө илүү хариуцлага хүлээдэг нь дээрх байдалд нөлөөлдөг. Хувийн хэвшлийн ЕБС-ийн суралцагчид төрийн өмчийн ЕБС-ийн сурагчдаас илүү үр дүнтэй суралцдаг хэдий ч тухайн хувийн хэвшлийн ЕБС-ийн шууд нөлөө гэж үзэх хангалттай нотолгоогүй ажээ. Өөрөөр хэлбэл тухайн суралцагчийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг тооцоолж хийсэн судалгаа бараг байхгүй байна.

Мөн хувийн хэвшлийн ЕБС-ийн үйлчилгээг хүртэгчид сургуулийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог, шийдвэрт нөлөөлдөг, хувийн сургуулиуд хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, шаардлага, гомдолд хариу үйлдэл үзүүлдэг гэсэн хангалттай нотолгоо олдоогүй байна. Зарим улс орнуудад засгийн газрын зүгээс шаардлагатай зохицуулалт, чанарын хяналт тавихгүйгээр хувийн хэвшлийн дэмжиж байгаа нь харагдсан байна. Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг хувийн сургуулиудын чанар, тэгш байдал, тогтвортой байдлыг сайжруулдаггүй нь харагдсан байна. Төрийн өмчийн ЕБС-тэй зах зээлийн түвшинд өрсөлдсөнөөр боловсролын тогтолцооны хүрээнд чанарыг нийтэд нь дээшлүүлнэ гэсэн таамаглалыг баталсан нотолгоо сул байжээ.<sup>10</sup>

Хувьчлалыг дэмжих бодлогууд нь ихэвчлэн «боловсролын шинэчлэл»-ийн нэрийн дор төвийг сахисан байдлаар тодорхойлогддог ч үнэн хэрэгтээ нотолгоо султай, алдаатай үзэл суртлыг илэрхийлсэн байдаг тул төрийн салбарын

8 Frank Adamson, PhD, Senior Policy and Research Analyst, Stanford Center for Opportunity Policy in Education (SCOPE), 2017 September 8<sup>th</sup>. PEHRC meeting

9 Ази тивээс Энэтхэг, Пакистан, Бангладеш, Балба; Африк тивээс Нигер, Кени, Танзани, Гана, Өмнөд Африк, Малави; Карибын бүсээс Ямайка багтсан.

10 Олон улсын хөгжлийн газар, Хөгжиж буй улсуудын хувийн сургуулийн үүрэг, нөлөө, 2014 оны 4 дүгээр сар. Дэлгэрэнгүйг: [https://www.gov.uk/government/uploads/system/uploads/attachment\\_data/file/439702/private-schools-full-report.pdf](https://www.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/439702/private-schools-full-report.pdf)



шинэчлэлийг үр дүнтэй болгох хүрээнд тэдгээрийг зайлшгүй эргэж харах шаардлагатай<sup>11</sup> гэж үзжээ.

## МОНГОЛ УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТОЙМ

Монгол улсын Үндсэн хуульд төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно, иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно<sup>12</sup> гэж заасан. Монгол улс өмчийн төрөл, хэлбэрийг харгалзахгүйгээр боловсролын байгууллагад адил тэгш хандах зарчмыг боловсролын хуулиндаа тодорхойлсон. Мөн хуулийн дагуу өмчийн хэлбэр харгалзахгүйгээр цэцэрлэг, ерөнхий боловсролын албан болон албан бус сургалтад хамрагдаж байгаа нэг суралцагчид ногдох сургалтын норматив зардлыг улсын төсвөөс санхүүжүүлдэг<sup>13</sup> зэргээр боловсролын хувийн салбарт төрөөс дэмжлэг үзүүлж байна.

2000 оноос хойш сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын салбарт төрийн бус өмчийн цэцэрлэг, сургууль болон түүнд хамрагдах сурагчдын тоо улам бүр өсөн нэмэгдсээр ирсэн, нэмэгдэх хандлага ч хэвээр байна. Төрийн болон төрийн бус өмчийн сургуулийн тоог Улаанбаатар хотын хувьд дүүргээр ангилан харвал зарим нэг дүүрэгт хувийн сургууль төрийн өмчийн сургуулиас тооны хувьд олон байгаа нь сонирхол татна. 2016-2017 оны хичээлийн жилд төрийн бус өмчийн 500 цэцэрлэг<sup>14</sup> ажиллаж байсныг 2018 онд 559 болгож, 133 сургууль ажиллаж байсныг 158<sup>15</sup> болгож тус тус нэмэгдүүлэхээр төсөөлсөн байна. Ийнхүү хувийн цэцэрлэг, сургуулиудын үүрэг оролцоо улам бүр өсөн нэмэгдэж байгаа нь төрийн зүгээс ачааллаа дийлэхгүй байгаа өнөөгийн нөхцөлд дэмжлэг болж буйг сайшаахын зэрэгцээ цаашид үүсч болзошгүй асуудлуудад олон улсын нэгэн адилаар анхаарал хандуулахын чухлыг тэмдэглэх нь зүйтэй.

Ялангуяа, ашгийн төлөө болон төлбөр төлдөг боловсролыг өргөжүүлэх нь төрөөс нийтлэг чанар, тэгш байдал, чанартай боловсрол олгоход бүрэн дүүрэн хангалттай байж чадахгүй байгаа төсвийн нэлээд хэсэг нь өөр тийш чиглэхээс гадна боловсролын тогтолцоонд гадуурхал, тэгш бус байдал улам нэмэгдэх магадлалтай. Уг нь төрийн бус өмчийн цэцэрлэг, сургуулиудын хувьд өөрийн хүсэл зориг, сэдэл тэмүүлээр үүсгэн байгуулагдаж, эцэг эхчүүдийн сонголтод

11 *Public good over private profit* • a toolkit for civil society to resist the privatization of education global campaign for education

12 Монгол Улсын үндсэн хууль, 1992 он, 2-р зүйл

13 Боловсролын тухай хууль

14 Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яам, “Сургуулийн өмнөх болон бага дунд боловсролын салбарын 2016-2017 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийн товч танилцуулга”

15 2018 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралт “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2018 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, Хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт”

суурилсан төлбөрөөр санхүүжиж, дээрээс нь төрөөс үнэ төлбөргүй боловсрол олгох үүргийнхээ хүрээнд олгодог нэг сурагчид ногдох хувьсах зардал болон бусад дэмжлэг туслалцааг авч байгаа утгаараа ямар ч тохиолдолд тэгш хамран сургалт, тэгш боломжийг хангасан, чанартай боловсрол олгох учиртай! Гэтэл бодит байдалд ялгаварлах, гадуурхах хандлага болон сөрөг асуудлууд хувийн сургуулиудын түвшинд нэмэгдсээр байна. Тодруулбал,

**Элсэлтийн хувьд:** Ихэнх сургуулиудын хувьд хүүхдийг шууд элсүүлдэг, түвшин тогтоох шалгалт авсан ч элсүүлэн сургах эсэхэд нөлөөлдөггүй ба олонд танигдсан, зарим сургуулиудын хувьд олон хүүхэд элсэх хүсэлт ирүүлсэн тохиолдолд сонгон шалгаруулалт зарладаг. Сайн мэдлэг, ур чадвартай, амжилт гаргасан суралцагчдыг шилж сонгох, хүүхдүүдийг өрсөлдүүлэх, нэг бол төлбөрийн чадавхтай, нийгэм, эдийн засгийн баталгаа бүхий өрхийн хүүхдийг суралцуулах, элсэн орсон суралцагчдын ололт амжилтыг шууд бусаар зар сурталчилгааны зориулалтаар ашиглах хандлага нийгэмд түгээмэл болжээ.

**Төлбөрийн хувьд:** Сургалтын төлбөрийг сургуулиуд дангаар, жил бүр нэмэгдүүлэх байдлаар тогтоож ирлээ. Сургалтын төлбөрийн зэрэгцээ, зарим сургуулиуд хүүхдийн дүрэмт хувцас, хоол, сурах бичиг, сонгон суралцах дугуйлан, унаа, хичээлийн дараах үйл ажиллагааны мөнгийг төлбөр дээр нэмж авч байна<sup>16</sup>. Эцэг эхийн чөлөөт сонголтоос илүүтэйгээр төлбөрийн нөхцөлд хэт анхаарч боловсролыг бизнесийн, арилжааны дэг жаягт хутгаж байна. Жишээ нь, хүүхдээ суралцуулахаар нэгэнт өгсөн бол дараа жилийн суудлыг нь хадгалж, урьдчилгаа төлбөр төлүүлэх, хүүхдээ шилжүүлвэл нэг улирлын хичээлийн төлбөртэй тэнцэх хэмжээний зардлыг суутгах зэргээр гэрээ байгуулдаг сургуулиуд байдаг байна. Түүнчлэн, төлбөрийн асуудлаас болж сургуулийн орчинд сургалтын төлбөрөө төлсөн, төлөөгүй гэдгээр, мөн үе тэнгийнхний дунд хувийн, төлбөртэй сургуульд сурдаг, баян айлын хүүхэд гэх мэтээр ялгаварлан гадуурхах, дээрэлхэх, дээрэмдэх явдал гарч байдаг талаар эцэг эх, хүүхдийн төлөөлөл дурдан тэмдэглэсэн байдаг.

**Чанартай боловсрол олгохын хувьд:** Гүнзгийрсэн сургалттай, эсвэл сургалтын орчин, дэд бүтэц хангалтгүй шалтгаанаас хүүхдүүдийн дуртай хичээлүүд нь хязгаарлагдах зэргээр сургалтын хөтөлбөр, стандартыг зүй ёсоор мөрдөхгүй, багшлах боловсон хүчнийг бүрдүүлэхдээ туршлагатай, сайн багш нартай харилцан тохиролцож улсын сургуулиас татан авах хандлага давамгайлж байна. Гэрээ байгуулан ажиллуулж байгаа багш нарынхаа мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаанд анхаарал бага хандуулдаг, төрийн захиргааны байгууллагын зүгээс хувийн сургууль цэцэрлэгийн багш нарыг мэргэжлийн болон арга зүйн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд хамруулахгүй орхигдуулж байна. Хувийн

16 “Хувийн хэвшлийн ерөнхий боловсролын сургуульд төрөөс үзүүлж байгаа санхүүгийн дэмжлэг, түүний үр нөлөө” судалгааны тайлан. “Бүх нийт боловсролын төлөө” Иргэний нийгмийн үндэсний эвсэл.

цэцэрлэгүүдийн хамран сургалт тогтворгүй, багш нь байнга солигдон, насны холимог бүлгээр сургаж, нэг цэцэрлэгт хүүхэд тогтмол удаан хугацаагаар хамрагддаггүй зэрэг шалтгаанаас үүдээд хувийн цэцэрлэгүүдийн чанар төрийн өмчийн цэцэрлэгүүдээс доогуур байна<sup>17</sup>.

**Мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдал.** Хувийн хэвшлийн ЕБС-ийн зүгээс эцэг эх, багш, ажилтнуудад төсвийн зарцуулалт, суралцагчдын төлбөр, бусад эх үүсвэрээс авсан хандив, санхүүжилтийн тухай мэдээлэл тэр бүр нээлттэй байдаггүй байна. Хувийн сургуулиуд эцэг эхчүүдээс авдаг сургалтын төлбөрөөс гадна, улсын төсвөөс хувьсах зардлын санхүүжилт авдаг талаар тэнд ажилладаг ихэнх багш нар, эцэг эхчүүд мэддэггүй байна<sup>18</sup>. Түүнчлэн, Боловсролын яам сургалтын төлбөрийн мэдээ цуглуулан тоон баримт бүрдүүлдэггүй, төсвийн санхүүжилтийн зарцуулалтын ил тод байдалд хяналт тавьж, боловсролын удирдлагын мэдээллийн системд санхүүжилтийн мэдээллийг уялдуулаагүй явж иржээ.

**Төрийн албан хаагчдын ашиг сонирхлын зөрчил.** Хувийн цэцэрлэгүүдийн чанараас шалтгаалан хамран сургалт тааруу болоход боловсролын яамны зүгээс багш нарын хүүхдийг үнэ төлбөргүй хамруулах нэрийдлээр хаагдахад хүрсэн цэцэрлэгүүдэд хувьсах зардлаар санхүүжилт хийж байгаа нь хувийн цэцэрлэгтэй төрийн албан хаагчдын ашиг сонирхлын зөрчилтэй үйлдэл гэж харагдаж байна. Хувийн их дээд, дунд сургууль, цэцэрлэгтэй УИХ, ЗГ, ИТХ-д байгаа шийдвэр гаргагчид нь хувийн сургуулиудын талаарх төрийн зохицуулалтыг боомилж байгаа үйлдлийг ашиг сонирхлын зөрчил гэж иргэний нийгмийн байгууллагууд үзэж байна.

Дээрх асуудлуудад хяналт тавих, зохицуулах явдал дутагдаж байгаа учраас хувийн хэвшлийн сургуульд сурч байгаа хүүхэд сурч боловсрох эрхээ бүрэн дүүрэн эдэлж чадахгүй, эсвэл чанаргүй боловсрол эзэмших магадлал нэмэгдэж болзошгүй эрсдэл харагдаж байна. Төрийн бус өмчийн цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааг зохицуулсан Монгол Улсын боловсролын салбарын эрх зүйн зохицуулалтуудыг олон улсад шалгуур болгон хэрэглэдэг 19 зохицуулалтын төрөл тус бүрээр нь авч үзсэн судалгааны тайланд<sup>19</sup> дараах 6 чиглэлд эрх зүйн зохицуулалт “байхгүй” болон “хангалтгүй” гэж дүгнэжээ. Үүнд:

- Хувийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хүүхэд элсүүлэх
- Сургалтын чанарыг тогтмол хангах, сайжруулах
- Сургалтын төлбөр тогтоох

17 Монгол улсын сургуулийн өмнөх боловсрол: Үйлчилгээний хүртээмж, чанар ба хүүхдийн хөгжлийн дүн, 2016, Дэлхийн банк

18 “Хувийн хэвшлийн ерөнхий боловсролын сургуульд төрөөс үзүүлж байгаа санхүүгийн дэмжлэг, түүний үр нөлөө” судалгааны тайлан. “Бүх нийт боловсролын төлөө” Иргэний нийгмийн үндэсний эвсэл.

19 “Монгол Улс дахь төрийн бус өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хамаарах эрх зүйн орчинд дутагдаж буй зохицуулалтыг тодорхойлох нь” судалгааны тайлан. Т. Энхжаргал

- Сургууль, цэцэрлэг дэх авлигатай тэмцэх зохицуулалт, үр дүн бүхий дотоод хяналтын тогтолцоо бий болгох
- Боловсролын сургалтын байгууллагын зар сурталчилгаанд тавих хязгаарлалт
- Ялгаварлан гадуурхахгүй байх, хүртээмжтэй байдлыг баталгаажуулсан эрх зүйн зохицуулалт зэрэг болно.

## ЦААШИД ЯАХ ЁСТОЙ ВЭ?

Төр,

- Олон улсын хүний эрхийн гэрээ, баримт бичгүүдээр хүлээсэн үүргүүдтэй нь зөрчилдөхгүй байх
- Ялангуяа нийгмийн бүлгүүдийн хувьд боловсрол эзэмших боломж хэт ялгаатай болоход хүргэхгүй байх
- Бүх нийтийн үнэ төлбөргүй, чанартай боловсрол олгох улс орны хүчин чадавхийг сулруулахгүй байх
- Зар сурталчилгаа, маркетингийн үйл ажиллагаагаар боловсролын тогтолцоог арилжааны хэлбэрт оруулахгүй байх явдлыг хангаж ажиллахын тулд юуны түрүүнд зохицуулалт бий болгох онцгой үүрэгтэй<sup>20</sup>.

Онолын хувьд ч, практикт ч тэр улс орнууд эдийн засгийн боломж, чадварыг харж сонголт хийдэг, ашгийн төлөө ажилладаг, эсвэл арилжааны чиглэлтэй, ялгаварлан гадуурхал гаргадаг, чанарын шаардлага хангаж чадахгүй байгаа зэргээр эрх зүйн хүрээнд хуулиар хүлээсэн үүрэгтэй нь зөрчилдөх ямар ч сургуулийг цаашид санхүүжүүлж, дэмжлэг үзүүлэх ёсгүй. Хэрэв санхүүжүүлдэг бол сургуулиуд стандартын шаардлага хангаагүй үед эсвэл санхүүжилтийн үр нөлөө боловсрол эзэмших эрхийг хэрэгжүүлэхэд саад болж байвал санхүүжилтийг буцаан татах эрх нь хэзээд төрд байна. Санхүүжилт үзүүлдэг бол төрийн энэхүү санхүүжилт нь төрийн сургуулиудад хангаж чадахгүй байгаа цөөнх, эмзэг, ядуу бүлгийн хэрэгцээг хангах зорилгод нь тус нэмэр болсон, тодорхой бүс нутагт төрийн хүчин чадавх хүрэлцэхгүй байгаа байдлыг арилгахын тулд тусгай арга хэмжээ авахад чиглэсэн эсвэл улсын сургуулиар үнэ төлбөргүй, чанартай боловсрол эзэмших хүртээмж хүн бүрт байгаа нөхцөлд боловсрол эзэмших эрхийн хэрэгжилтийг улам өргөжүүлж баталгаажуулахад зорих ёстой.

Улмаар, цуглуулсан мэдээлэлд хяналт шинжилгээ хийж, асуудалтай, дутагдалтай талуудыг илрүүлсний үндсэн дээр нийгмийн бүхий л талуудын

20 Төрийн болон төрийн бус сургалтын байгууллагуудаар дамжуулан боловсролын үйлчилгээг хүргэхэд улс орнуудын баримтлах хүний эрхийн зарчмууд. Удирдамж баримт бичиг

оролцоог хангасан, ил тод үйл явцаар зөвшилцөж хэлэлцэж байж цаашид хэрэгжүүлэх бодлогын зорилтуудыг тодорхойлох ёстой. Ингэхдээ улс орнуудын туршлага, сургамж, сайн жишээнээс суралцаж өөрийн онцлог, нөхцөл байдалд тохируулан авч үзэх нь зүйтэй. Ихэвчлэн дэлхийн өмнөд бүс нутгийн бага болон дунд орлоготой орнуудын нөхцөл байдалд түлхүү суурилсан ч дэлхийн өнцөг булан бүрээс хуримтлагдсан туршлага, жишээн дээр тулгуурлаж боловсруулсан гарын авлагуудад<sup>21</sup> танилцуулсан нийтлэг зөвлөмжөөс энд хуваалцаж байна.

---

## ЕРӨНХИЙ ЗОРИЛТ:

### **ХУВИЙН СУРГУУЛИУДЫН ТАЛААР БАРИМТЛАХ ЗОХИЦУУЛАЛТЫН МЕХАНИЗМ БИЙ БОЛГОХ**

#### **Дэд зорилт 1. Нийгмийн сайн сайхан, үндэсний эв эе, иргэн төлөвшүүлэх:**

- Сургалтын хөтөлбөр, сурах бичиг болон сургалтын бусад материалууд, сургалтын үйл ажиллагаанд, сургалт явагдаж байгаа хэлэнд хяналт тавих
- Хэвшмэл ойлголт, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх тодорхой стандарт болон хяналт тавих аргачлал, дүрэм журам гаргах

---

#### **Дэд зорилт 2. Сургуулийн чанарыг дээшлүүлэх, зах зээлийн алдаа гажгийг нөхөх, чанарыг баталгаажуулах наад захын стандартуудыг дараах чиглэлээр мөрдүүлэх:**

- Багш нар: багш нарын мэргэжил, ур чадварын шаардлага, багш сурагчийн харьцаа, багшийн цалингийн шатлал, доод хэмжээг тогтоох, багшийн хөдөлмөр эрхлэлтийн нөхцлийг зохицуулах
- Материаллаг дэд бүтэц: анги танхим, бусад өрөө танхим, орчин, хөгжлийн бэхшээлтэй хүүхдийн орчин, эрүүл ахуй, аюулгүй байдлын гэх мэт шаардлага тавих
- Сургалтын орчин ба хэрэглэгдэхүүн: сурах бичиг, мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдхүүн, номын сан гэх мэт
- Үндэсний цөм хөтөлбөр, стандарттай нийцсэн сургуулийн сургалтын хөтөлбөр, үнэлгээний систем
- Хүүхэд хамгаалал (бэлгийн дарамт, бие махбодийн шийтгэлээс урьдчилан сэргийлэх гэх мэт)

---

21 *Public good over private profit, Иргэний нийгмийн байгууллагуудад зориулсан гарын авлага.* Дэлхий дахины Боловсролын төлөөх Олон улсын хөдөлгөөн (GCE)

---

### **Дэд зорилт 3. Ил тод байдлыг дэмжих, сургуулиудын талаар мэдээлэл дутуу дулимаг байгааг нөхөх, хуурч мэхэлдэг сургуулиудыг илрүүлэн үйл ажиллагааг зогсоох**

- Төрийн яамны цахим хуудас зэрэг олон нийтийн мэдээллийн орон зайд сургуулиудын талаар нээлттэй, тогтмол хугацаанд шинэчлэгддэг мэдээллийг тавих (төсөв, төгсөлтийн хувь, олсон ашиг гэх мэт)
- Санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын механизм бий болгох, үр дүн, тайлангийн товъёог олон нийтийн орон зайд нээлттэй тавих
- Хувийн сургуулиудыг хянах, зохицуулах, журамлах орон тоо, санхүүжилттэй механизм бий болгох
- Хууль, дүрэм журмыг зөрчсөн сургуулиудад үе шаттай торгууль ногдуулах, эцсийн арга хэмжээ нь хаах хүртэлх тогтолцоог бий болгох, хаах тохиолдолд хүүхдүүдийг өөр сургуульд шилжүүлэх зэргээр завсрын арга хэмжээг авах
- Хувийн сургуулиудад тавих олон нийтийн хяналтыг бэхжүүлэх, эцэг эхэд сургуулийн захиргаатай, өмчлөгч талтай хэлэлцээ хийх бүтэц бий болгох, сургууль дээр эцэг эх-багшийн холбоо байгуулахыг хуульчлах
- Сурагч болон эцэг эхийн дуу хоолойг сонсох орон зайг бий болгохын тулд санал гомдол хүлээн авч шийдвэрлэх маш тодорхой тогтолцоог хуульчлах

---

### **Дэд зорилт 4. Бүх хүүхдэд хүртээмжтэй байх боломжийг тэгшитгэх, боловсролын тэгш бус байдал, тусгаарлагдсан байдлыг арилгах**

- Сургалтын төлбөрт “тааз” тавих
- Хувийн сургуулийн элсэлтийг зохицуулах тодорхой механизм байх, элсэлтийн далд төлбөрийг үгүй хийх, ил тод шалгаруулалт явуулах гэх мэт
- Сургалтын төлбөрөө төлж чадахгүй эцэг эхчүүдийн хүүхдийг, ядуу айлын элсэн орсон хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй байх, эмзэг бүлгийн, ядуу айлын хүүхдүүдэд дэмжлэг, хөнгөлөлт үзүүлэх тогтолцоотой байх,
- Хөрөнгө чинээтэй хэсэг хувийн сургуульд, ядуу айлын хүүхдүүд улсын сургуульд гэсэн тусгаарласан байдал бий болсон улс орнуудад хувийн сургуульд заавал элсүүлэх квот тогтоож өгсөн байдаг гэх мэт

## Монгол улсад хувийн сургуулиудыг зохицуулах чиглэлээр гарч байгаа ахиц дэвшлүүд

Боловсролын үйлчилгээ үзүүлэгч хувийн байгууллагын сургалт, үйлчилгээг дан ганц зах зээлийн шаардлага, суралцагчийн эрэлт хэрэгцээг хангахад бус харин олон нийтийн сайн сайхны төлөө, тогтвортой хөгжлийн үзэл санаанд нийцсэн байдалтай хөгжүүлье гэвэл холбогдох бүх зохицуулалтад онцгой анхаарал хандуулах нь зүйтэй.

Боловсролын тухай хуулийн холбогдох заалтын дагуу төрийн болон төрийн бус өмчийн сургалтын байгууллагыг тогтмол болон нормативт зардлаар санхүүжүүлж байна. Засгийн газраас 2016 онд “Хувьсах зардлын дундаж норматив, санхүүжүүлэх аргачлал батлах тухай” 242 дугаар тогтоолыг батлан төрийн болон төрийн бус өмчийн хүүхдийн цэцэрлэг, ЕБС, МСҮТ-ийн нормативт зардлыг олгож байна.

Тухайн тогтоолоор нэг сурагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативаар санхүүжих аргачлал, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг тооцох бүрэлдэхүүн, төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээг тусад нь баталж өгснөөрөө онцлогтой болж хувьсах зардлын санхүүжилтийг улам нарийвчлан хуваарилах боломжийг олгосноороо онцлогтой байна.

Мөн төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн санхүүжилтийг олгохдоо тухайн боловсрол сургалтын байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ, боловсролын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл, төсвийн төсөлд өгсөн саналыг үндэслэн олгохоор зохицуулсан. Мөн төсвийн төлөвлөлт хийхдээ тухайн боловсрол сургалтын байгууллагын сургалтын төлбөр тогтоосон шийдвэрийг баримтлахаар тогтоосон.

Төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээг төлбөргүй болон 5 сая төгрөг хүртэлх төлбөртэй, 10 сая төгрөг хүртэлх төлбөртэй, 10 сая төгрөгөөс дээш төлбөртэй гэсэн гурван ангиллаар ялгаатай олгохоор зохицуулсан.

Сургалтын нормативт зардлын санхүүжилтийг аймаг, нийслэлийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтэс сар бүр хүүхэд өдрөөр хянаж, төсвийн санхүүжилтийн сар, улирлын хуваарьт дагуу сар тутамд олгох зэрэг нарийвчилсан зохицуулалтууд орж ирсэн.

## Филиппин улсын Боловсролын эвслийн нөлөөллийн баримт бичгээс

№	Зохицуулалт хийх гол асуудлууд
1	Хувийн өмчийн цэцэрлэг, сургуулийг үүсгэн байгуулах болон “тусгай зөвшөөрөл олгох” улсын бүртгэлд бүртгүүлэх дүрэм, журам
2	Хувийн өмчийн цэцэрлэг, сургуульд тавигдах шалгуур үзүүлэлт, (тусгай зөвшөөрлийн шаардлага) магадлан итгэмжлэлийн шаардлагууд
3	Санхүүжилтын түвшин, механизм (төсвөөс санхүүжилтээ авах, зарцуулах, тайлагнах гэх мэт үйл явцыг шаардсан байдлаар журамласан байх)
4	Татвар болон гаалийн хураамж
5	Хувийн өмчийн цэцэрлэг, сургуулийн засаглал, удирдлагатай холбоотой дүрэм журам
6	Хувийн өмчийн цэцэрлэг, сургуульд элсүүлэх, хамран сургах журам
7	Сургалтын хөтөлбөр
8	Өдөр тутмын үйл ажиллагаа
9	Мэдээллийг нийтэд, эсвэл эцэг эхэд ил тод болгох шаардлагууд
10	Багш, сурган хүмүүжүүлэгчдийн үйл ажиллагааг зохицуулсан зохицуулалт
11	Багшийн ажиллах нөхцөл, статус, багшийн мэргэжил эзэмшсэн байдал, мэргэшүүлэх сургалт, цалин болон мэргэжлийн ур чадварт тавигдах стандартууд
12	Сургалтын чанарыг баталгаажуулах дүрэм, журам, үйл явц
13	Сургалтын төлбөрийг тогтоох аргачлал ( хэрхэн тогтоох, хэн хэн оролцох, төрөөс хэрхэн хянах гэх зэргийг зохицуулсан эсэх удирдамж)
14	Эрүүл ахуй, аюулгүй байдал
15	Хувийн өмчийн сургууль, цэцэрлэгийн авлигатай тэмцэх хууль зүйн зохицуулалт эсхүл өндөр үр дүнтэй дотоод хяналтын тогтолцоо
16	Эцэг эхийн оролцоог дэмжсэн зохицуулалт
17	Багш нарын холбоог дэмжих баталгаа (Үйлдвэрчний эвлэл, эвлэлдэн нэгдэх байгууллага байгуулах эрхийг баталгаажуулсан)
18	Хувийн өмчийн сургууль, цэцэрлэгийн олгож буй боловсролын чанарын талаарх мэргэжлийн хяналт шалгалт
19	Боловсролын зар сурталчилгаанд нийтийн сайн сайхны тусын тулд хяналт тавих эрх зүйн зохицуулалт
20	Ялгаварлан гадуурхахгүй байх болон хүртээмжтэй байдлыг баталгаажуулсан эрх зүйн зохицуулалт (Хөгжлийн бэрхшээлтэй, ядуу, гэх мэт хүүхдийг элсүүлэн сургах байдлыг баталгаажуулсан эсэх)



# Төрийн өмчийн сургуулиудыг чанартай болгож чадах уу?

ЗӨВ БОДЛОГЫН ХУВИЛБАР<sup>22</sup>

Боловсролд төрөөс хөрөнгө оруулах хандлагыг баримтлах нь



UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

22 Frank Adamson, PhD, Senior Policy and Research Analyst, SCOPE

## “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн ТУНХАГ

Боловсрол нь хүн бүрийн өдөр тутмын амьдралд, насан турш нөлөөлөх үндсэн эрх, хүний хөгжлийн түлхүүр бөгөөд иргэн бүрт чанартай боловсрол олгох нь төрийн хүлээх гол үүрэг хариуцлага гэдэгт итгэн;

Өнөөгийн тогтолцоонд боловсролыг явцуу тодорхойлдог, хүн бүрийн ялгаатай байдлыг харгалздаггүй, ялгаварлан гадуурхдаг, хангалттай санхүүжилт олгодоггүй зэргээс шалтгаалан бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх үйл явцад цогц хандлага дутагдаж; боловсролын тогтолцооны үр өгөөж нь хувь хүний хүсэл тэмүүлэл, нийгмийн эрэлт хэрэгцээнээс асар зөрүүтэй байсаар ирсний улмаас үнэ цэнэтэй амьдарч, амьдралын чанараа дээшлүүлэх боломж олгохгүй байгаад сэтгэл зовнин;

Энэ нь эрх мэдлийн шударга бус бүтцийг бий болгож, тэгш бус байдлыг хадгалж үлдэх арга зам болж байгааг эсэргүүцэн;

Боловсролын чанар, хүртээмж, хариуцлагатай байдлын төлөө хүчээ нэгтгэн ажиллаж, энэ үйл явцад хувь хүн, иргэний нийгмийн байгууллага, бүлгүүдийг өргөнөөр татан оролцуулж, өргөн суурьтай, зохион байгуулалттай, хүчтэй хөдөлгөөн бий болгохыг чухалчлан;

Энэ үйл явцад нийгмийн бүх бүлэг, ялангуяа эрх мэдлийн цөөнхийн оролцоог хангахыг онцлон;

Иргэд, бүлгүүдийн мэдлэг, чадварыг хөгжүүлж, тулгарсан асуудлаа гаргаж ирэх, шийдлийг шаардах, хариуцлага тооцох чадавхтай болоход нь дэмжлэг үзүүлэхийг эрмэлзэн;

Боловсролын тогтолцоог хүний мэдэх, бүтээх, хүний ёсоор хамтран амьдарч, нэр төртэйгээр оршиход суралцахуйц, хувь хүний потенциал, чадвар, чадавхыг нээж, эерэг зан үйл, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн, хүмүүнлэг, ардчилсан, хүн бүрийн эрхийг хангасан, тэгш хүртээмжтэй болгон өөрчлөхийг эрхэмлэн;

Хүүхэд, эцэг эх, багш, орон нутгийн бүлгүүд болон үндэсний, хэлний, соёлын, бэлгийн цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, орлого багатай иргэд зэрэг дуу хоолойгоо хүргэж, шийдвэр гаргахад оролцож чадахгүй байгаа бүлгүүдийг эрх мэдэлжүүлэх зорилгоор боловсролын тогтолцоо, бодлогод хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чадавхыг бүрдүүлэх, нөлөөлөх ур чадвараа дээшлүүлэх шаардлагыг ухамсарлан;

Хүний эрх, жендэрийн тэгш эрх, үл ялгаварлан гадуурхах, хүчирхийллээс ангид, хүлээцтэй байх, нээлттэй, ил тод, хариуцлагатай байх зарчмыг баримтлан;

Монгол улсад боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах, төсвийг хянах, хариуцлага шаардах, бодлогод нөлөөлөх үндэсний кампанит ажил зохион байгуулах зорилгоор эвсэн нэгдсэнээ тунхаглаж байна.

2010 оны 9 сарын 3

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

UIH.MN  
СУДАЛГААНЫСАН